



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 4/77

Модот

Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/275 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 8-наас 20 хоногийн хугацаанд зохион байгуулах, Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд ажиллах хүн хүч машин техник шатах тослох материаллын бэлэн байдлыг хангаж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд даалгасугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалт хийх ажлыг малчидад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэн мал сүргээ бэлэн байлгахыг Багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийсэн малчид мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн этгээдэд хуулийн дагуу арга хэмжээ тооцож ажиллах, дархлаажуулалтанд шаардлагатай вакцин татан авах, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлд хяналт хийн ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (П.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг засаг даргын орлогч (Б.Болорцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ЗОЛЖАРГАЛ



Сумын Засаг даргын 2024 оны 08
сарын 09-ны өдрийн А/77 дугаар
захирамжийн хавсралт

**Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамрагдах
мал, тарилгын хуваарь**

№	Аж ахуйн нэр	Хамрагдвал зохиx малын тоо		Бүгд	Шаардагдах вакцин\тун\	Шингэлэгч
		Хонь	Хурга		тун	л
1	Дэрст хайрхан МЭҮН	48257	15143	63400	63400	63400
2	Үржих баян мандал МЭҮН	20466	6734	27200	27200	27200
3	Цэнхэр бэлчир МЭҮН	9085	1715	10800	10800	10800
	Бүгд	77808	23592	101400	101400	101400